



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 23 өдөр

Дугаар 2/32

Хэрлэн сум

Шагнаж, хөрөнгө зарцуулах

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2021 оны А/105 дугаар захирамжийн гуравдугаар хавсралтын дагуу 2023 оны үйл ажиллагааны ерөнхий үнэлгээгээр 1, 2, 3, 4, 5 дугаар байр эзэлсэн сумдын Засаг даргын Тамгын газрыг урамшуулахад зориулж 3,450,000 (гурван сая дөрвөн зуун тавин мянган) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Шаардагдах зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3.1 дүгээр байр эзэлсэн сумын Засаг даргын Тамгын газрын даргад үндсэн цалингийн 80%, 2 дугаар байр эзэлсэн сумын Засаг даргын Тамгын газрын даргад үндсэн цалингийн 60%, 3 дугаар байр эзэлсэн сумын Засаг даргын Тамгын газрын даргад үндсэн цалингийн 40%-тай тэнцэх мөнгөн урамшууллыг байгууллагынх нь төсвөөс олгохыг зөвшөөрсүгэй.

4. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Засаг даргын нөөц сангийн шагнал урамшуулал, нэг удаагийн буцалтгүй тусламж, дэмжлэгийн зардлаас олгохыг Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын  
оны 01 дүгээр сарын 23-ны  
дугаар захирамжийн хавсралт

Шаардагдах зардлын тооцоо

№	Зардлын нэр	Тоо	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ
1	1 дүгээр байрын шагнал	1	1.000.000	1.000.000
2	2 дугаар байрын шагнал	1	800.000	800.000
3	3 дугаар байрын шагнал	1	600.000	600.000
4	4 дүгээр байрын шагнал	1	400.000	400.000
5	5 дугаар байрын шагнал	1	400.000	400.000
6	Батламж	5	50.000	250.000
	Дүн			3.450.000